



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ  
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 45 дугаар зүйл 45.2 дах заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/179 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, Эрүүл мэндийн салбарын их засвар төсөл арга хэмжээний хүрээнд батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн гадна фасадны засвар, дээврийн засвар болон дулааны шугам засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	А.Болор-Эрдэнэ /Санхүү, аж ахуйн албаны дарга, ахлах нягтлан бодогч/
Нарийн бичгийн дарга:	Ж.Мягмарсүрэн /Хүний нөөцийн менежер, хуулийн зөвлөх/
Гишүүд:	Ж.Батжаргал /Хоол судлалын төвийн дарга/ Л.Энхболд /Аж ахуйн менежер/ Б.Болорцэцэг /Эдийн засагч/ П.Бат /Монголын өрөмдлөгийн холбоо ТББ/ Ч.Тэмүүлэн /Барилгын аюулгүй ажиллагааг дэмжих төв ТББ/

2. Засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн материалыг үндэслэл сайтай боловсруулж, сонгон шалгаруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн болон холбогдох журмын дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга /А.Болор-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЦОГТБААТАР